

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ТҮҮНТЭЙ ХОЛБОГДОХ БУСАД ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуульд шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал, хэрэг, маргааныг шүүхээр хянан шийдвэрлэхэд иргэдийн төлөөлөгчдийг оролцуулах, мөн шүүгч, Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөлийн тухай зэрэг шүүх эрх мэдэлтэй холбоотой олон заалт байдаг.

Өнгөрсөн хориод жилийн хугацаанд манай улсын шүүхийн тухай хууль тогтоомж, бодлогын баримт бичиг шинэчлэгдэн батлагдаж, хэрэгжиж ирсэн. Гэвч өнөөдөр хууль, шударга ёс алдагдаж байгаатай холбоотой, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж буй шүүгч, шүүхийн хараат бус байдал алдагдсан тухай санал шүүмжлэл тасрахгүй байгаа нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд голлох үүрэгтэй шүүхийн институтын бие даасан байдал, үйл ажиллагаанд нийгэм сэтгэл ханамжгүй байгааг харуулж байна. Үүнийг гадаад, дотоодын олон удаагийн судалгаа ч давхар нотолж байна. Нөгөө талаар, шүүхэд шинэтгэл хийхийг шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа шүүгчид өөрсдөө хүсч байгаа нь шүүхийн тухайхуулийн төсөл, түүнтэй холбогдсон бусад хуулийн төслүүдийг боловсруулах, хэлэлцүүлэх үеэр ажиглагдсан болно. Өөрөөр хэлбэл, шүүхийн шинэтгэлийг гүнзгийрүүлэхийг аль аль талдаа хүсч байгаа бөгөөд шинэтгэл хийх бүхий л нөхцөл бүрдсэн гэж хэлж болно.

Ийм учраас өнгөрсөн хориод жилд шүүхийн шинэтгэлийн талаар хийсэн ажлын ололттой хийгээд сул тал, хөгжлийн эрх ашиг, цаашдийн чиг хандлагыг харгалзан үзэж шүүхийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх зорилт хурцаар тавигдаж байна. Үүнийг шийдвэрлэхийн тулд манай улсын хөгжлийн эрэлт хэрэгцээ, олон улсын хөгжлийн чиг хандлагатай нийцүүлж, шүүх эрх мэдлийн байгууллагын бие даасан байдлын баталгаа, ажиллах орчныг эрс сайжруулах, нөгөө талаар тэнд ажиллах хүмүүст тавих шаардлагыг өндөржүүлж, хариуцлагажуулах, шүүхийн үйл ажиллагааны үр ашиг, ил тод байдлын түвшинг дээшлүүлэх улмаар шударгаар хэрэг, маргааныг шийдвэрлэх тогтолцоог бий болгоход чиглэсэн Шүүхийн тухай /Шинэчилсэн найруулга/, Шүүхийн захиргааны тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн төслүүдийг боловсруулна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 3-т “Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана”, мөн зүйлийн 5-д “Шүүхийн ерөнхий зөвлөлийн зохион байгуулалт, үйл

ажиллагааны журмыг хуулиар тогтооно”, дөчин есдүгээр зүйлийн 4-т “Шүүхийн ерөнхий зөвлөл шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр, гагцхүү хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зэрэг шүүхийг бие даан ажиллах нөхцөлөөр хангахтай холбогдсон үүргийг биелүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлэх үүднээс шүүхийн удирдлага зохион байгуулалт, хүний нөөц, санхүүжилт, материал техникийн хангамж, мэдээллээр үйлчлэх чиг үүрэгтэй байгууллагын статустай болгох үзэл баримтлалыг эдгээр хуулийн төсөлд удирдлага болгов. Түүнчлэн, тавин хоёрдугаар зүйлийн 2-т анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг хуульд заасан журмын дагуу оролцуулна гэж заасныг бодит утгаар хэрэгжүүлэхээр иргэдийн төлөөлөгчийн эрх хэмжээ, оролцох механизм болон зохион байгуулалтыг хуулиар нарийн зохицуулах Үндсэн хуулийн үзэл санааг баримтлал болгов.

Улсын Их Хурлын 2009 оны 35 дугаар тогтоолоор баталсан “Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.4, 4.1.5, 4.1.13 дахь заалт, Улсын Их Хурлын 2009 оны 38 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл”-ийн 91, 94, 96, 112 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2009 оны 105 дугаар зарлигаар батлагдсан “Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.1-3.3 дахь заалт, Засгийн газрын 2009 оны 69 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийн 7, 8, 15, 16, 48-д заасныг үндэслэл болно.

Улсын Их Хурлаас 1998 оны 18-р тогтоолоор баталсан “Монгол Улсын Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр” болон Улсын Их Хурлын тогтоолоор 2000 онд батласан “Монгол Улсын шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө”-нд тусгагдсан шүүхийн салбарын шинэчлэл, үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилтыг бүрэн хангахыг уг хуулиудын төслийг боловсруулахдаа харгалзан үзсэн болно.

Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын үндсэн зарчим, түүнийг хангах механизм, баталгаа, шүүхийг олон нийтэд ойртуулах, үйл ажиллагааг нь хялбаршуулж, нийтэд ил тод, дөхөмтэй болгох зэрэг асуудлаар НҮБ-аас гаргасан “Шүүхийн байгууллагын хараат бус байдалд хамаарах үндсэн зарчим”, Европ дахь шүүхийн хараат бус байдлын тухай харти зэрэг олон улсын эрх зүйн хэм хэмжээ, АНУ, ХБНГУ, Франц, Япон, БНСУ зэрэг гадаад орнуудын шүүх эрх мэдлийн тогтолцооны тухай хууль тогтоомж, практик, дэлхийн улсуудын шүүхийн тогтолцооны тухай лавламж ашиглаж хуулийн зохицуулалтыг дэлхий нийтийн чиг хандлагад нийцүүлэхийг зорилоо.

2000 онд Улсын Их Хурлаас баталсан “Монгол Улсын шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө”-нд хийсэн үнэлгээ, мониторингийн тайлан, Улсын дээд шүүх, Хууль зүйн үндэсний хүрээлэн зэрэг төрийн болон Нээлттэй нийгэм форум зэрэг төрийн бус байгууллагаас хийсэн судалгааны дүгнэлт, “Шүүх эрх мэдлийн шинэтгэл ба шудрага ёс” үндэсний чуулганаас гарсан санал, зөвлөмж, шүүх болон хууль хяналтын бусад байгууллагуудын ажилтан, албан хаагчидтай хийсэн удаа дараагийн уулзалтаас гаргасан санал, хүсэлт нь энэхүү хуулийн төслийг боловсруулах болсон практик үндэслэл болно.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Шүүхийн тухай хуулийн төсөл нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх зарчим, Монгол Улсын шүүх, Улсын дээд шүүх, давж заалдах шатны шүүх, анхан шатны шүүх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх баталгаа гэсэн ерөнхий бүтэцтэй бөгөөд шүүхийн зохион байгуулалт, тогтолцоо, бүрэн эрх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх баталгаа болон үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулна.

Шүүхийн захиргааны тухай хуулийн төсөл нь Ерөнхий зөвлөлийн бүрэн эрх, чиг үүрэг,Ерөнхий зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, Шүүхийн захиргааны байгууллага,шүүхийн ажилтны эрх зүйн байдал,бусад зүйл гэсэн ерөнхий бүтэцтэй. Энэхүү хуулийн төслийн зорилт нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх, шүүхийн өдөр тутмын тасралтгүй үйл ажиллагааг зохион байгуулах үндсэн чиг үүрэг бүхий Шүүхийн ерөнхий зөвлөл болон шүүхийн захиргааны чиг үүрэг, зохион байгуулалт, үйл ажиллагааны зарчим, шүүхийн ажилтны эрх зүйн байдлыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл нь шүүгчийн эрх зүйн байдлын нийтлэг үндэслэл, шүүгчийн бүрэн эрх үүсэх, дуусгавар болох, шүүгчийн хараат бус байдал, түүнийг хангах баталгаа,шүүгчийн хариуцлага, хүлээлгэх хариуцлага гэсэн ерөнхий бүтэцтэй. Энэ хуулиар Монгол Улсын Үндсэн хуульд заасан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх онцгой чиг үүрэг бүхий шүүгчид тавих шаардлага, шүүгч сонгон шалгаруулах журам зэрэг шүүгчийн эрх зүйн байдалтай холбогдсон харилцааг зохицуулахад хуулийн зорилго оршино. Бүх шатны шүүхийн шүүгчийн хараат бус, халдашгүй, эрх мэдэл бүхий, шударга, хариуцлагатай байдлыг хангах, үйл ажиллагаандаа хууль дээдлэх ёс, шүүхийн ёс зүйг нарийн чанд сахин биелүүлэх эрх зүйн үндсийг тогтоон зохицуулна.

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл нь шүүн таслах ажиллагаанд оролцож байгаа иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулах, түүний үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна. Энэ хуулиар иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн статус, шалгуурыг тодорхойлж, иргэдийн төлөөлөгчийг шүүх хуралдаанд бодитой, үр нөлөөтэй оролцох боломжийг бүрэн нээж, холбогдох зохицуулалтыг нарийвчлан оруулсан. Түүнчлэн иргэдийн төлөөлөгчийн оролцоог хангах талаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн чиг үүргийг тодорхойллоо.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн төсөл нь эрх зүйн маргааныг зуучлагч хөндлөнгийн этгээдийн оролцоотойгоор зохицуулах шүүхийн бус аргыг хэрэглэх эрх зүйн үндсийг бий болгох, иргэний эрх зүйн харилцаанаас үүссэн, тэдгээрийн дотор аж ахуйн болон эдийн засгийн бусад үйл ажиллагаатай холбоотой маргаан, түүнчлэн хөдөлмөрийн болон гэр бүлийн харилцаанаас үүссэн маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хэрэглэх харилцааг зохицуулна.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын шүүхийн өнөөгийн тогтолцоог Үндсэн хуулийн үзэл баримтлалын хүрээнд шинэчлэн тогтоох, хэрэг, маргааныг тухайн чиглэлээр мэргэшсэн шүүгч, шүүх бүрэлдэхүүн хянан шийдвэрлэж байх замаар “Шударга, хариуцлагатай шүүх засаглал” бүрэн утгаараа төлөвшин, шүүхэд итгэх олон нийтийн итгэл, хандах хандлагыг сайжруулах ач холбогдолтой. Түүнчлэн, шүүхийн тогтолцоонд тойргийн зарчим нэвтрүүлснээр шүүхийн харилцан адилгүй ачааллыг зохистой болгох, засаг захиргааны хөндлөнгийн нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зэрэг ач холбогдолтой. Түүнчлэн, эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагааг нэвтрүүлснээр шүүхийн ачаалал буурахын зэрэгцээ маргаанаа өртөг, зардал багатай шийдвэрлүүлэх шинэ механизм бий болох ач холбогдолтой.

Шүүхийг эрүү, иргэн, захиргаа зэрэг хэрэг, маргааны төрлөөр дагнан байгуулснаар шүүгч мэргэшиж, шийдвэрийн чанарт нөлөөлөн улмаар иргэний шударга шүүхээр шийдүүлэх эрхийн нэг үндэс болно.

Бие даасан, үр нөлөөтэй шүүх эрх мэдэл нь манай улсын нийгэм, эдийн засгийн тууштай хөгжлийг хангах баталгааг бүрдүүлэх, шүүх гүйцэтгэх засаглалаас хараат бусаар, бие даасан байдлаар үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг хангах зорилгоор “шүүхийн эдийн засгийн баталгаа”-г зарчмын өөр байдлаар шийдвэрлэх зэргээр эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болно.

Хууль батлагдсанаар шүүхийн захиргаа төлөвшин хөгжиж, шүүх бүр өөрийн

захиргаа, менежменттэй байх шинэ нөхцөл бий болно. Шүүхийн ерөнхий зөвлөлийн үйл ажиллагаа Үндсэн хуулийн үзэл баримтлалд бүрэн нийцэж, эрх зүйн зохицуулалт улам боловсронгуй болно.

Шүүхийн үйл ажиллагааг олон түмэнд ил тод болгон шүүгчээр нэр дэвшүүлэх, томилох, эсхүл татгалзах үндэслэлүүдийг зохицуулж, шүүгчид тавигдах өндөр хариуцлагыг бий болгосноор шүүхийг аливаа нөлөөнөөс хамгаалах эрх зүйн үндэс төлөвшиж бэхжинэ. Шүүгчийн халдашгүй байдал хуульчлагдан тогтож, түүний амь бие, орон сууц, албан байр, тээвэр, холбооны хэрэгсэл, эд хөрөнгийг гэмт халдлага, засаг захиргааны дур зоргоос хамгаалах үндэс бүрдэнэ. Улмаар шударга, хариуцлагатай шүүгч төлөвшиж нийгэм дэх шүүхэд итгэх итгэл, хандах хандлага өөрчлөгдөнө.

Иргэдийн төлөөлөгчийн эрх хэмжээг тодорхой болгосноор шүүхэд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, Үндсэн хуулийн заалт, үзэл санаа бүрэн утгаар нь хэрэгжих ба шүүхийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод, шударга байх олон нийтийн үнэлэмж дээшилж нийгмийн шүүхэд итгэх итгэл, хандах хандлага сайжирна. Түүнчлэн, иргэдийн эрх зүйн ухамсар дээшлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал

Энэхүү хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулна.

Энэ төслийг Шүүхийн захиргааны тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай зэрэг хуулийн төслүүдийн хамт баталснаар одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Шүүхийн тухай хуулийг бүхэлд нь хүчингүй болгоно. Мөн бусад холбогдох хуулийн төслүүдэд дагалдах нэмэлт, өөрчлөлтүүд боловсруулна.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ